

2015.05.01-ноос 2015.05.29-ны өдрийн хооронд ирсэн мэдээлэл, түүний шийдвэрлэлт

| No | Огноо      | Иргэн | Нэр         | Товч утга  | Шилжүүлсэн байдал |            | шалгасан байцаагч  | Шийдвэрлэсэн байдал  |
|----|------------|-------|-------------|--|-------------------|------------|--|--|
|    |            |       |             |  | Аль нэгжийн хэнд  | Огноо      |  | Хэрхэн шийдвэрлэсэн  |
| 1  | 2015.06.03 | Иргэн | Нямдэлгэр   | Сансарын тунелын хойно, “Жүмонг” солонгос рестораны хажуу дах ногоо зардаг /Жаргалант/-павильон худалдагч хүн загнаад байна  | МХЕГ              | 2015.06.03 | Улсын байцаагч Б.Ганболд   | Гомдол гаргасан иргэнтэй утсаар ярьж, МХБ-ын харъяалалын асуудал биш тул Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төвд хандах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгөв.  |
| 2  | 2015.06.04 | Иргэн | Эрдэмтөгс   | БГД, гэмтлийн эмнэлгийн урд байрладаг “Алякса” эмнэлэг эмчилгээ эрхлэх зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэж, иргэдэд үйлчилээд байна. Шалгаж өгнө үү.   | БГД-ийн МХХ       | 2015.06.04 | ЭТҮЧАБХУАБ Д.Соёлмаа   | Иргэний мэдээллийн дагуу “Алякса” эмнэлэгийн байрлаж буй байранд очиход тус эмнэлэг ажиллаагүй байгаа тул холбогдох газруудад хандаад байна. Энэ дагуу мэдээллийг гомдол гаргагчид утсаар мэдэгдсэн  |
| 3  | 2015.06.04 | Иргэн | Баасансүрэн | БЗД-ийн 15–р хороо 7б байрны хажууд байрлах хувийн байранд төмөр ерөмдөөд оршин суугчдын амгалан тайван алдагдуулаад байна. Шалгаж өгнө үү   | БЗД-ийн МХХ       | 2015.06.04 | Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ж.Цэрэнпагма | Нийтийн орон сууцны барилгын айл өрхийн засварын ажил түүний дуу чимээ гаргаж байгаад шалгалт хийхийг хориглоно гэсэн заалт МХЕГ-ын даргын 2014 оны 177 дугаар тушаалаар заасан байдаг тул шалгах хяналтын чиг үүрэгт хамааралгүй тул тухайн өргөдлийг хаав.   |
| 4  | 2015.06.04 | Иргэн | Цэцгээ      | Дундговь аймгийн адаацаг сумын дэлгүүрүүдээр хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн худалдаж байна.Шалгаж өгнө үү.   | ХХААХГ            | 2015.06.04 | Улсын байцаагч Я.Батцагаан   | Дундговь аймгийн МХГ-ын МЭ-ийн хяналтын улсын байцаагч Е.Отгонцэцэг уг гомдлын дагуу шалгалт хийхэд гомдол гаргагч хүний 95861201 тоот утас нь "Ашиглалтанд байхгүй" дэлгүүрийн нэр нь тодорхой бус, гомдол нь хугацаа хоцорч ирсэн тул шалгалт хийх боломжгүй байна. Сумын МЭ-ийн байцаагч 2015 оны 05 дугаар сард зөвлөн туслах үйлчилгээг бүх дэлгүүрүүдэд үзүүлж зөвлөгөө өгсөн байна. |
| 5  | 2015.06.05 | Иргэн | Долгоржав   | Чингэлтэй дүүрэг 7 дугаар хорооны нутаг ХГ-ийн 11-20 тоотын дэргэд хогийн цэг төвлөрүүлээд, хогоо ачиж явахгүй удаашруулсан болхоор тухайн хог нь орчин бохирдуулаад байна. Яаралтай шалгаж өгнө үү. | ЧД-ийн МХХ        | 2015.06.05 | Улсын ахлах байцаагч Ч.Мөнхбаяр                                    | Гомдол гаргасан иргэнтэй утсаар ярьж, МХБ-ын харъяалалын асуудал биш тул Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төвд хандах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгөв.  |

|   |            |       |           |  |             |            |   |   |
|---|------------|-------|-----------|--|-------------|------------|---|---|
| 6 | 2015.06.08 | Иргэн | Эгшигхүү  | Баруун дөрвөн зам, Нарантуул зочид буудлын зүүн талд эмийн сан шинээр нээгдсэн байна. Ойр орчимд олон эмийн сан байдаг бөгөөд эдгээр эмийн сангууд зөвшөөрөлтэй эсэх, 500 м хүрэхгүй ийм олон эмийн сан байж болох эсэх. Шалгаж өгнө үү  | ЧД-ийн МХХ  | 2015.06.08 | Улсын байцаагч Д.Отгонпүрэв, М.Лхагвасүрэн                      | 2015.06.11-ны өдрийн 09.30 цагт гомдол гаргагч Эгшигхүүтэй утсаар холбогдож эмийн сангуудын тусгай зөвшөөрөл болон хаягийн шилжилт хөдөлгөөний асуудлыг НЭМГ-ын шинжээчдийн баг газар дээр очиж үзэж дүгнэлт гаргадаг учраас эмийн сангуудын зөвшөөрлийн асуудлаар НЭМГ-т хандахыг зөвлөв.  |
| 7 | 2015.06.08 | Иргэн | Сүрэн     | Өгөөмөр зах дотор болон тус захын 00 дотор жижиглэн бараа, хоол хүнс, ус ундаа, тамхи ширхэглэж зарж байгаа бөгөөд захын удирдлагуудад хэлэхээр хүлээж авахгүй байна. Тус захад арга хэмжээ авч өгнө үү. (Өгөөмөр захыг хаах эсвэл хотоос гаргах саналтай байна.) Арга хэмжээ авч өгнө үү.   | БЗД-ийн МХХ | 2015.06.08 | Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Д.Оюунбат | Хүнсний тухай” хуулийн 10.1.1-т үйл ажиллагаа эрхлэгч нь үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, сөрөг үр дагаварыг өөрөө хариуцахаар заасан тул тус хэлтэс нь дээрх гомдлын дагуу шалгах боломжгүй байна.   |
| 8 | 2015.06.08 | Иргэн | Мөнхцэцэг | Санзайн зуслангийн замыг 2013, 2014 онуудад засварлаж байсан. Гэвч зам нь маш их эвдэрснээс машин явахад шороо, тоос их босч, айлууд руу орж ирэх болсон. Уг замыг МХЕГ-аас 2014 онд шалгаж, дүгнэлт гаргаж байсан юм байна. Энэ тухай МХЕГ-ын вэб хуудас дээр байршуулсан байна. Уг дүгнэлтийн дагуу зөрчлийг арилгуулах арга хэмжээ авагдсан болов уу? Санзайн замыг дахин газар дээр нь ирж шалгаж өгнө үү. | ДБХГ        | 2015.06.08 | Улсын байцаагч С.ГАНбаатар                                      | НМХГ-ын авто замын хяналтын улсын байцаагч Д.Дуламрагчаа иргэнтэй утсаар холбогдож БХЯ-аас хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, үлдсэн ажлыг гүйцэтгүүлэх, барилга угсралтын ажлын явцад гүйцэтгэлийн шалгалтыг хийж мэдэгдэхээр болсон.  |
| 9 | 2015.06.08 | Иргэн | Саруул    | Интерферон хүүхдийн лааг хөргөгчинд хадгалаж борлуулах заавартай юм байна лээ. Гэтэл хувь хүн гар дээрээс буюу фэйсбүүкийн Памперс центр групп-ээр Enhsaihan Bayarmaa гэх иргэн борлуулж байна. Шалгаж өгнө үү.  | ЭМБСХГ      | 2015.06.08 | Улсын байцаагч Ч.Отгонцэцэг                                     | Иргэн Саруултай 99235725 дугаарын утсаар холбогдож Энхсайхан, Баярмаа 96693962, 96657281 гэсэн дугааруудыг авч 96693962 гэсэн утсаар Интерферон лаа худалдан авах тухай ярихад гэрт чинь хүргэж өгье /ажил тараад/ гэсэн хариу өглөө. Иймд байгууллагын чиг үүргийн дагуу Цагдаагийн газарт шилжүүлэх нь зүйтэй байна. Асуудлыг ЭМБСХГ-ын дарга Н.Гансүхэд танилцуулахад Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт хийхэд асуудлыг шалгахаар шийдвэрлэв. |

|    |            |       |             |  |             |            |   |   |
|----|------------|-------|-------------|--|-------------|------------|---|---|
| 10 | 2015.06.08 | Иргэн | Оюун        | Би Эрин эмнэлэгийн захирал Оюун гэдэг хүн байна. БГД-ийн Мария гэдэг хятад эмнэлэгийг шалгаж өгнө үү. Тус эмнэлэгт мэргэжлийн эмч ажилтан байна уу? 77 настай эмээг үтрээний үрэвсэлтэй гэж буруу оношилж, баахан зураг авхуулж, мөнгө нэхсэн байна. Хэдийгээр 77 настай энэ хөгшин гомдол гаргаагүй ч би өмнөөс нь гомдол гаргаж байна. Энэ хүнд буруу онош тавьж, төлбөр авсан эмнэлэг, эмнэлэгийн эмчийг шалгаж өгнө үү. Ер нь Хятад эмнэлэг болон хятад эмч нартай эмнэлэгт хатуу хяналт тавьж ажилламаар байна. Шалгаж өгнө үү. | БГД-ийн МХХ | 2015.06.08 | ЭАХХ хяналтын улсын байцаагч И.Наранцэцэг                 | Гомдлын дагуу шалгалт хийх тухай хэлтсийн даргын 27-03/60 тоот удирдамжийн дагуу хамтарсан хяналт шалгалт хийж шалгалтын явцад илэрсэн зөрчлийг үндэслэн эмнэлэгийн үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоох тухай улсын байцаагчийн 27-03-249/50 тоот акт гарган хүргүүлсэн. Гомдол гаргагчид утсаар хариу мэдэгдсэн |
| 11 | 2015.06.09 | Иргэн | Н.Хүрлээ    | 6 нэрийн барааны дэлгүүр ажилуулдаг. Одоо харин 8 нэрийн барааны дэлгүүр ажилуулах хүсэлтэй байна. Иймд хаана хандаж, ямар зөвшөөрөл авах вэ?  | МХЕГ        | 2015.06.09 | Өргөдөл, гомдол албан бичиг хариуцсан ажилтан Т.Ганжаргал | Хүсэлт ирүүлсэн иргэн Н.Хүрлээтэй холбогдож 8 нэрийн барааны зөвшөөрлийг Нийслэлийн засаг даргын тамгын газарт хандаж авах тухай зөвлөгөө өгч хаав.   |
| 12 | 2015.06.09 | Иргэн | Нарангэрэл  | Хүнсний бүтээгдэхүүн, эм, эмийн бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн мөн дотоодын хүнсний болон эм, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн нэрс, утасны жагсаалт, хаяг хэрэгтэй байна. ШӨХТГ  | МХЕГ        | 2015.06.09 | Өргөдөл, гомдол албан бичиг хариуцсан ажилтан Т.Ганжаргал | Хүсэлт ирүүлсэн иргэн Нарангэрэлтэй холбогдож зөвлөгөө өгч хаав.  |
| 13 | 2015.06.09 | Иргэн | Ариунболд   | Бариж байгаад зогссон нэлээн удсан барилгаа үргэлжлүүлэн барих гэсэн юм. Интернетээс хархаар зөрүүтэй мэдээллүүд байгаад байна. Иймд үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулахад хаана хандаж, ямар зөвшөөрөл авах вэ?  | МХЕГ        | 2015.06.09 | Өргөдөл, гомдол албан бичиг хариуцсан ажилтан Т.Ганжаргал | Иргэн Ариунболдтой холбогдож, барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг НЕТГ хандаж авах хэрэгтэй гэсэн зөвлөгөөг өгч хүсэлтийг хаав.  |
| 14 | 2015.06.09 | Иргэн | Э.Соёлчимэг | Манай лабораторийн үйл ажиллагаа явуудаг байгууллага юм. Өөрийн байгууллагынхаа ажлын байрны нөхцөлийг тодорхойлуулах гэсэн юм. Тэгэхээр хаана хандаж, ямар бичиг баримт бүрдүүлэх вэ?   | МХЕГ        | 2015.06.09 | Өргөдөл, гомдол албан бичиг хариуцсан ажилтан Т.Ганжаргал | Иргэнтэй Э.Соёлчимэгтэй холбогдож, албан бичгээр МХЕГ-ын хөдөлмөрийн нөхцөл, хэмжил судалгааны төвд хандах шаардлагатай гэсэн зөвлөгөөг өгөв.   |

|    |            |       |          |   |             |            |                       |  |
|----|------------|-------|----------|---|-------------|------------|-----------------------|--|
| 15 | 2015.06.09 | Иргэн | Ц.Санжаа | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо “Япон цэргийн дурсгалд зориулсан цогцолбор” өнгөрөөд барилгын газар шорооны ажлыг шөнийн цагаар хийгээд байна. Хорооны засаг даргаас асуухаар мэдэхгүй гэсэн хариу өгөөд байна. Энэ хийгдэж байгаа барилгын ажил нь зөвшөөрөлтэй эсэхийг тодруулан шалгаж өгнө үү.   | НМХГ        | 2015.06.09 | ДБХХ                  | СБД 15-р хороо 2015 оны 6-р сарын 27ны өдөр шалгалт хийхэд айлууд суурьшихаар уулын хормойг буулгаж газар тэгшилж байв. Одоогоор барилгын ажил эхлээгүй байна. Иргэн Ц.Санжаатай утсаар холбогдож мэдэгдхийг хүссэн боловч утсаа авсангүй.   |
| 16 | 2015.06.09 | Иргэн | Л.Гэрлээ | Баянгол дүүргийн 15 дугаар хорооны 30 дугаар байранд “Мистер пицца” байрладаг. Тус 30 дугаар байрны иргэд бидэнд пицца хийж байгаа үнэр, тахианы махны үнэр, гол нь газны үнэр үнэртээд тайван амьдрах нөхцөл байдд сөргөөр нөлөөлж байна. Мөн явган хүний зам дээр машинаа байрлуулдаг, машинаа уугаан орчныг бохирдуулдаг энэ аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагааг нь зогсоож иргэд бидний тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж өгнө үү. | БГД-ийн МХХ | 2015.06.09 | ЭАХХХУБ<br>Л.Энхцэцэг | Хэлтсийн даргын 27-03/68тоот удирдамжийн дагуу шалгалт хийж зөрчлийг арилгуулахаар 27-03-242/56 тоот улсын байцаагчийн актаар үйл ажилагааг түр хугацаатай зогсоож гомдол гаргачид хариу өгсөн   |
| 17 | 2015.06.09 | Иргэн | Одмаа    | Блю Скай Тауэр цогцолбороос ярьж байна. Манай урд талд шинээр барилга барьж байгаа юм. Өдрийн цагаар барилгын үйл ажиллагаа явуулахдаа хуурай цементыг орчиноор нэг таарааж байна. Энэ нь бидний ажил хийх нөхцөлийг хүндрүүлэх сөрөг нөлөөллийг /сахиар хийсэн цонхоор орж ирэх, цээж хорсгох/ үзүүлж байна. Иймд энэ байдлыг харгалзан үзэж хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн холбогдох арга хэмжээг авч өгнө үү.   | НМХГ        | 2015.06.09 | НМХГ                  | 2015.06.11-ны өдрийн 10:30 цагт газар дээр нь очин хянан шалгалт хийв. Өргөдөлд дурьдсан асуудлаар шаардлага тавьж уг үйл ажиллагааг энэ өдрийн 15:00 цагт бүрэн зогсоох, барилгын хамгаалалттай хашаа, саравч татах үүрэг өгөв. Иргэн Н.Одмаад барилгын талбай дээрээс утсаар ярин холбогдов. |

|    |            |       |            |  |             |            |                                |   |
|----|------------|-------|------------|--|-------------|------------|--------------------------------|---|
| 18 | 2015.06.10 | Иргэн | Х.Уртнасан | Боловсролын их сургуулийн урд талд байрлах Сонор плаза, Төгөлдөр, Буянт, Долоон булаг төвүүдийн үүдэнд хүнсний зүйл /тамхи, уднаа, чихэр, печень/-сийг зараад байна. Үүнээс үүдэн орчин тойрныг бохирдуулан ихээхэн хэмжээний хог үүсч байгаа нь тэнд ажиллаж, амьдарч хүмүүсийн эрүүл ахуйд сөргөөр нөлөөлж байна. Нийтийн эзэмшлийн газар ингэж хүнсний бүтээгдэхүүн зарах зөвшөөрөл олгодог юм уу. Үүнийг түргэн шуурхай шалган шийдвэрлэж өгнө | СБД-ийн МХХ | 2015.06.10 | Улсын байцаагч З.Зоригтхүү     | Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч З.Зоригтхүү тус дүүргийн 8,11 дүгээр хорооны нутаг дэвсгэр дээр буюу Боловсролын их сургуулийн орчимд гар дээрээс худалдаа хийж буй хүмүүс дээр очиж хяналт шалгалт хийхэд СБД-н Засаг даргын 2015.05.27-ны өдрийн А218 тоот захирамжийн хүрээнд үйлдвэр үйлчилгээний хэлтсээс холбогдох зөвшөөрлүүдээ авсан байв. Иргэнд утсаар хариу мэдэгдсэн болно. |
| 19 | 2015.06.10 | Иргэн | П.Нэргүй   | Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт орших Баян модотын уурхай ой модон дунд газар ухаад байна. Үүнийг шалган шийдвэрлэж өгнө үү.  | БОГУУХГ     | 2015.06.10 | Улсын байцаагч Д.Сансардарьмаа | Хэнтий аймгийн МХГ-ын дэд бүтэц, байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч, хэлтсийн дарга Д.Шараа хариуг хүргүүлэхээр хүсэлт гаргасан иргэний 96666985 тоот утас руу залгахад холбогдох боломжгүй байв.   |
| 20 | 2015.06.11 | Иргэн | Д.Баатар   | Өчигдрөөс хойш Хил, хорио цээрийн хяналтын газартай холбогдох гээд болохгүй байна. 51-263150 дугаарын утасруу залгахад утсаа авахгүй байна. Энэ тал дээр арга хэмжээ авч өгнө үү.  | ХХЦХГ       | 2015.06.11 | Улсын байцаагч Э.Уламбаатар    | 2015.06.15-ны өдөр иргэн Баатартай утсаар холбогдож 263150 дугаарын утсаар холбогдож үүссэн нөхцөл байдлын талаар тодруулсан. Тухайн өдөр би бухимдалтай байсан тул 1800-1286 утас руу залгаж хэлсэн. Гэхдээ өдөртөө энэ асуудлаа шийдвэрлүүлсэн ямар нэг гомдол саналгүй гэсэн хариу өглөө.  |
| 21 | 2015.06.15 | Иргэн | Цэвэлмаа   | Ховд аймгийн зэрэг суманд байдаг урт цагааны 8-р байрны хажуу талын байрыг нураасан хогоо цэвэрлээгүй үлдээсэн. "Хос төөрөг" гэдэг компани нураасан боловч хогоо цэвэрлэхгүй явсан. Энэ хогыг цэвэрлүүлэх тал дээр анхаарч өгөөчээ.  | МХЕГ        | 2015.06.15 | МХЕГ                           | МХБ-ын харъяалалын асуудал биш тул сумынхаа Засаг даргад хандах шаардлагатай талаар зөвлөгөө өгөхөөр иргэн Цэвэлмаагийн 94725825 дугаарын утас руу залгаж зөвлөгөө өгсөн.   |
| 22 | 2015.06.15 | Иргэн | Баярсайхан | Урт цагааны урд талын 6-р байр хөөрөг дэлгүүрийн 2 давхарт алт мөнгөний дархан 52, 53 тоотыг худалдаж аваад алт мөнгөний дархан ажиллуулаад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулж байна. Орон сууцанд ийм үйл ажиллагаа явуулж болох уу? Шалгаж өгнө үү.  | НМХГ        | 2015.06.15 | ХНХХХ                          | Тус гомдлыг шалгаж үзэн ЧД-ийн 3-р хороо 6-р байрны 52,53 тоотод алт мөнгөний дархан, хөөрөгний засвар үйлчилгээ явуулж байсныг 2016-06-26-ны 33-06-384/184 тоот улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг зогсоож иргэн Л.Баярсайханд хариу өглөө.   |

|    |            |       |             |   |             |            |  |   |
|----|------------|-------|-------------|---|-------------|------------|--|---|
| 23 | 2015.06.15 | Иргэн | Бат-Эрдэнэ  | Цамбагарав титэм плазагын урдаас харсан хүнсний дэлгүүрээс кекс авсан хөгзөрчихсөн байна. Ороод хэлсэн боловч тоохгүй байна. Энэ гомдолыг шийдвэрлэж өгнө үү  | СХД-ийн МХХ | 2015.06.15 | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Ч.Одонгэрэл | Удирдамжийн дагуу хяналт шалгалт хийхэд 22 ширхэг хугацаа хэтэрсэн цагаан кекс “Бадрах өгөөж” ХХК худалдаалж байсныг хурааж авлаа. Тус компанийн дэлгүүрт зөрчлийг арилгуулах улсын байцаагчийн албан шаардлага өгч хуулийн дагуу 150 000 төгрөгийн шийтгэвэрийн арга хэмжээ авлаа.   |
| 24 | 2015.06.15 | Иргэн | Энхжаргал   | Төв музейн хажууд байрлах Даблю барилгаас юм унаж хүний толгойг хагалж, хөлийг гэмтээлээ. Шалгаж өгнө үү.   | НМХГ        | 2015.06.15 | ДБХХ, ХНХХХ  | Гомдол гаргагчийн утасны дугаар өөр, энэ дугаарт Энхжаргал гэгч хүн байхгүй. Объектийн байршил тодорхой бус Шалгалт хийх боломжгүй байна. Жич Үндэсний музейн урд МҮЭ-ийн захиалгат барилга Байгалийн музейн хойд хэсэгт Асар-Өргөө ХХК буулгалтын үйл ажиллагаа эрхлэж байгаа тус газруудад дээр дурьдсан үйл явдал гараагүй байна.  |
| 25 | 2015.06.16 | Иргэн | Мөнхтуяа    | Баянзүрх дүүргийн 13 дугаар хороололын миний дэлгүүрээс 06 дугаар сарын 15-ны өдрийн 12-13 цагийн хооронд хонины мах худалдаж авч хоол хийж идээд гэр бүлээрээ хордлого аваад байна. Одоогоор түргэн дуудаад байна, энэ асуудлыг шалгаж өгнө үү | БЗД-ийн МХХ | 2015.06.16 | Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч П.төгсмаа          | Гомдол гаргасан иргэн Мөнхтуяатай уулзаж хордлогын шинжилгээний хариу болон дэлгүүрээс худалдаж авсан бүтээгдэхүүнийг чинь шинжилгээнд өгнө гэхэд хийгээд идчихсэн гэв. Гэртээ бүтээгдэхүүнээрээ буцалгаж хоол хийж идсэн байв. Бүтээгдэхүүн нь байхгүй тул шинжилгээнд хамруулж шалгах боломжгүй тухай тайлбарлаж тухайн өргөдлийг хаав  |
| 26 | 2015.06.16 | Иргэн | Нандинцэцэг | Улаанбаатар хотын сэлбийн голд барилгын хог хаягдал хийгээд байна. Үүнийг шалгаж өгнө үү  | НМХГ        | 2015.06.16 | БОГУУХХ  | Иргэний гомдлын дагуу 2015.06.17 өдөр хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар Ууангс “Эдэлвайз” ХХК нь орон сууцны төслийг хэрэгжүүлэх явцад барилгын талбайгаас хөрсний ус гарч хөрсний усанд “Монгол ус” ТӨҮГазраар ашиглуулах дүгнэлт гаргуулан “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-тай хөрсний ус зайлуулах шугам холбон ус шавхах гэрээ байгуулан ажиллаж байна. |

|    |            |       |               |  |             |            |  |  |
|----|------------|-------|---------------|--|-------------|------------|--|--|
| 27 | 2015.06.16 | Иргэн | Ганбаатар, Од | БГД-ийн 3 хороо Нарны хорооллын байшин бүрийн подволь дэлгүүрт нийт 20 гаруй газарт архи, тамхи зараад байна, арай дэндэж байна, зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж зогсоомоор байна. Шалгаж хариуг яаралтай өгнө үү  | БГД-ийн МХХ | 2015.06.16 | ХҮАБХ-ын улсын байцаагч Д.Саруул   | 88061753 утсаар Одтой холбогдоход дугаартаа байгаагүй. Дахин залгахад найз нь дуудаж яриулахад гомдлыг Од гэгч өөрийн дугаараар өгөөгүй гаргасан гомдлын утгыг сайн мэдэхгүй нотлох баримтгүй, подваль дэлгүүрийн давхрыг тодорхой мэдэхгүй байсан тул гомдлоо буцааж авахаар шийдвэрлэв.  |
| 28 | 2015.06.16 | Иргэн | Болормаа      | СХД-ийн 22-р хороо “Зуун алдар” супермаркет нь засвар хийж байгаа мөртлөө үйлчилгээ үзүүлээд байна, хүнсний зүйл нь шороо тоос ихтэй байна, үүнийг шалгаж яаралтай арга хэмжээ өвч өгнө үү   | СХД-ийн МХХ | 2015.06.16 | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Ч.Одонгэрэл | “Зүүн алдар” ХХК-ний хүнсний дэлгүүр нь өргөтгөл хийж байсан ба гадна талын өрлөг хийх үед үйл ажиллагаа явуулсан харин дотор талын хана нураахад 4 хоног үйл ажиллагаа түр зогсоосон байна. Харин хяналт шалгалтыг хийх үед засварын ажил дуусч хэвийн үйл ажиллагаа явуулж байсан тул иргэн Болормаад 88607200 дугаарын утсаар хариу мэдэгдсэн болно.  |
| 29 | 2015.06.16 | Иргэн | Данзансамбуу  | БЗД-ийн дарь эхийн хуучин эцсийн автобусны буудлын Ачит тун эмийн сан нь бохир заваан бохир орчинд үйл ажиллагаа явуулж мэргэжлийн бус хүн ажиллуулж байна, мөн хугацаа дууссан эм зардаг газар байгаа юм, шалгаж, арга хэмжээ авч өгнө үү                     | БЗД-ийн МХХ | 2015.06.16 | Эмбиобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Э.Одонтуяа                       | Тус гомдлын дагуу шалгахад зөвшөөрөгдөөгүй эм зарж байснаас гадна, хаяг шошгийн зөрчилтэй байсан тул албан тушаалтанд 280,0 төгрөгийн торгууль ногдуулж ажиллав.   |
| 30 | 2015.06.16 | Иргэн | Бадамдорж     | СХД-ийн 31 хороо “Оранж” дэлгүүрээс боорцог худалдаж аваад хүүхэд идээд хордлого авч эмнэлэгт хэвтэж хордлого тайлуулах эмчилгээ хийлгэлээ, энэ дэлгүүр нь удаа дараа хөгзөрсөн талх, бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа тул шалгаж яаралтай хариу өгнө үү. | СХД-ийн МХХ | 2015.06.16 | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Ч.Одонгэрэл | СХД-ийн 31-р хороо ХХК-ний Оранж хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийхэд хяналт шалгалтын явцад Дархан хүнс ХХК-ний аарцтай боов байгаагүй t-230 хэм харьцангуй чийг 38 хувьтай байсан. Харин гомдол гаргагч иргэнтэй ярихад өөрөө тухайн үед согтуу байсан, хүүхэд биш харин өөрөө гэдэс нь өвдсөн тул эмнэлэгт очиж үзүүлсэн / өндөгнөөс цус авахуулсан / гэсэн боловч эмч Элбэгзаяа нь хордлого гэж оношлоогүй байна. Тус ААН-ийн дэлгүүрийг шийтгэвэрийн арга хэмжээ авлаа. |

|    |            |       |           |   |             |            |  |   |
|----|------------|-------|-----------|---|-------------|------------|--|---|
| 31 | 2015.06.16 | Иргэн | Батхүү    | БЗД-ийн Отгонтэнгэр дээд сургуулийн хажууд /Жуковын/ лянхьхо хятад хоолны газарт хоол идэж байсан чинь хоолноос том ялаа гарлаа, тогоочийг дуудсан боловч гарч ирэхгүй байна, энэ асуудлыг шалгаж өгнө үү   | БЗД-ийн МХХ | 2015.06.16 | Хүнсний чанаар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Б.Цэрэнханд | Тус гомдлын дагуу шалгахаар иргэн н.Батхүү рүү 88050398 утсаар нь холбогдож тодруулга авах гэсэн боловч би тийм гомдол гаргаагүй гэсэн хариу өгсөн тул тухайн гомдлыг үндэслэлгүй гэж үзэж хаалаа.  |
| 32 | 2015.06.17 | Иргэн | Монголмаа | Баянзүрх дүүрэг цагдаагийн газар шинэ баригдсан байруудад эмийн сангийн зөвшөөрөл өгөөгүй гэсэн боловч 15 – 3, 15 - 2 байруудад эмийн сан нээгдсэн байна. Үүнийг салгаж өгнө үү. Мөн эрүүл мэндийн 7-р төвд хуучин мөнхийн тун эмийн сан байж байгаад гараад оронд нь өөр эмийн сан орсон байна. Өөр эмийн сангийн зөвшөөрөл дээр орно гэж байдаг юм уу шалгаж өгнө үү. | БЗД-ийн МХХ | 2015.06.17 |  | Шалгалтаар зөвшөөрөлд заасан хаягаас өөр газарт үйл ажиллагаа явуулж байсан тул улсын байцаагчийн актаар үйл ажиллагааг түр зогсоож албан тушаалтанд хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулав.  |
| 33 | 2015.06.18 | Иргэн | Лхагва    | Баянбулаг баг Баян-өндөрийн 2-86-д зуны халуунд нэхий арьс аваад тэр нь өмхийрээд ялаа шаваад байна. Шалгаж өгнө үү.  | БОГУУХГ     | 2015.06.18 | УАБ Ч.Мөнхбаяр   | Гомдол гаргасан иргэн Лхагватай утсаар холбогдох гэсэн боловч 99356999 дугаар холбогдох боломжгүй гэсэн хариу өглөө. Гомдол гаргагчийн хаяг тодорхой биш тул уг гомдлыг хаав.   |
| 34 | 2015.06.18 |       |           | Яармагт байдаг сансар худалдааны төвөөс бурхан халдун архийг хаяа авч уудаг байсан. / өөрсдөө үйлдвэрлэдэг гэсэн/. Өчигдөр 0,5 бурхан халдун архийг авч уухад яг хятад спирт шиг байсан. Шөнөжин ходоод элэг цес нь өвдөж хонолоо. Иргэн гомдлыг нууцлахыг хүссэн.  | ХУД-ийн МХХ | 2015.06.18 | ХУД-ийн МХХ  | Гомдлын дагуу дээж авч шинжилгээний дүнгийн тухай 34-03-294/254 тоот улсын байцаагчийн дүгнэлт гаргав. Шинжилгээний дүнг үндэслэн 10 ширхэг архийг буцаан татав. 99734857 дугаартай утас шалгалтын явцад болон дараа нь холбогдох боломжгүй байсан. |
| 35 | 2015.06.19 | Иргэн | Ганшагай  | MGL цемент ХХК-д хөдөлмөрийн нөхцөл тодорхойлж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ үү. Үйлдвэрийн дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хөдөлмөрийн нөхцөл зөрчигдөж байгаа тул яаралтай шалгаж өгнө үү. Хаяг: СХД 22-р хороо хуучин 22 товчоо өөрийн үйлдвэрийн байр.   | ХНХХГ       | 2015.06.19 | ХНХХГ  | Иргэн гомдлоо буцаан татаж авсан тул гомдлыг хаав.  |



|    |            |       |             |   |             |            |  |  |
|----|------------|-------|-------------|---|-------------|------------|--|--|
| 36 | 2015.06.19 | Иргэн | Халиун      | БЗД-ийн 4-р хороо Доржийн гудамж 31-р байр хажууд шинээр баригдсан барилга нь нэг давхартаа гал тогооны өрөөтэй бөгөөд уг газраас гарах утаа, газан хийний үнэр нь тухайн байрны оршин суугчдын тав тухыг алдагдуулж байгаа тул зохих арга хэмжээг авч өгөхийг хүсэв.   | БЗД-ийн МХХ | 2015.06.19 | Эмбиобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Э.Одонтуяа | Тус хэлтэст барилгын, болон шингэрүүлсэн шатдаг хийн хяналтын чиглэлийн улсын байцаагч байхгүй тул шалгах боломжгүй байгаа тухай н.Халиунд мэдэгдэв. Уг асуудлын НМХГ-ын ДБХХ-ийн хяналтын чиглэлийн улсын байцаагч шалгана.                 |
| 37 | 2015.06.22 | Иргэн | Ч.Батжаргал | Хөвсгөл аймгийн МХГ-аас ямарч удирдамжгүй, хяналтын хуудасгүйгээр “Олон нийтийг хамарсан ажилд” хяналт шалгалт хийж байгааг шалгаж өгнө үү. Аймгийн МХГ-ын Нийгмийн хамгаалалын хяналтын улсын байцаагч Отгонцэцэг гэдэг нөхөр.   | ХНХХГ       | 2015.06.22 | УАБ П.Хорлоо                                       | 2015.06.24,24-нд 88384886 дугаарын утсаар холбогдож асуудлыг тодруулахаар залгасан боловч авахгүй байв. 70388424 дугаарын утас өөр хүн байв. 26-нд мөн 88384886 дугаарын утсаар залгасан боловч холбогдох боломжгүй байсан тул гомдлыг хаав. |
| 38 | 2015.06.22 | Иргэн |             | Төв аймгийн Аргалант сумын нутаг “Молцог элс” гэдэг газраас Эрдэнэт рүү хаваржин элс зөөж байсныг саяхан Хустайн цогцолборт газраас зогсоолоо. Иймд Сумын ИТХ-ын дарга Дэгдэлгүнсэл, Засаг дарга Сэргэлэн нарыг холбогдуулан шалгаж өгнө үү. Шалгалтыг МХЕГ-аар хийлгэх гэсэн юм. Аймгийн МХГ-аар шалгуулахгүй. | МХЕГ        | 2015.06.22 | МХЕГ   | Гомдол гаргасан иргэн нэр, холбоо барих утас хаягаа хэлээгүй тул гомдлыг шалгах боломжгүй болно.   |
| 39 | 2015.06.23 | Иргэн | Баянбат     | СБД, 1-р хороо Замын цагдаагийн газрын ард баригдаж байгаа 15 давхрын Жавхлантөгсийн барьж байгаа барилгаас юмс унаж байна. Саравч хамгаалалтын тор тавиагүй газар байна. Шалгаж өгнө үү.   | НМХГ        | 2015.06.23 | ДБХХ   | Тус байгууллагад хяналт шалгалт хийж 960.0 төгрөгний цахиргааний хариуцлага ноогдуулав.  |
| 40 | 2015.06.24 | Иргэн | Д.Бота      | Халуун ус тасарцан байхад халуун усны төлбөр аваад байна. Сарын авсан төлбөр дээрээ дараа сарын төлбөрөө нэмж аваад байна. БЗД 14 хороо цагаан хуаран контор. ШӨХТГ-т   | МХЕГ        | 2015.06.24 | МХЕГ   | Халуун усны төлбөр тооцооны асуудал нь МХБ-ы. Харьяалалын асуудал биш тул ШӨХТГ-т хандаж асуудлаа шийдвэрлүүлэхийг иргэнд зөвлөв.  |

|    |            |       |           |  |             |            |  |   |
|----|------------|-------|-----------|--|-------------|------------|--|---|
| 41 | 2015.06.24 | Иргэн | Одхүү     | БЗД-н 5-р хороо монгол кино үйлдвэрийн хойд талд ус сувгийн удирдах газрын хажууд 16 давхар орон сууц барьж байгаа. Шөнө оройгүй ажиллаад ажилчдын хоол хийхдээ гадаа гал түлж хийгээд хиншүү үнэртээд байна. Ойр хавьд нь оршин суухад хэцүү байна. Яаралтай арга хэмжээ авч өгнө үү. | НМХГ        | 2015.06.24 | ХНХХХ  | 2015.06.30-нд шалгаж БЗД-ийн 5 дугаар хороонд УСУГ-ын ажилчдийн орон сууцны барилгыг барьж буй "Гэрэгэ Констракшн" ХХК-д хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар тухайн барилгын талбайд гэр барьж, ажилчидад гадна пийшэнд гал түлж хоол хийж байсан. Иймд илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 7 заалт бүхий албан шаардлага "Гэрэгэ Констракшн" ХХК-д хүргүүлэв. |
| 42 | 2015.06.24 | Иргэн | Эрхэмбаяр | СХД, Мах импексийн Нүүдэл баншнаас цагаан утас гараад байна. Өчигдөр орой Далай ээжийн хажуу талын мини маркетаас авсан.   | СХД-ийн МХХ | 2015.06.24 | Мал амьтан хорио цээр, чанарын хяналтын улсын байцаагч Б.Дэлгэрмаа | Баншнаас цагаан утас гарсан болохыг нь нотлох баримт, эд зүйл байхгүй. /Тус иргэний ярьснаар Мах импекс ХХК холбогдох хүнтэй ярьж баншийг солиулж авсан оронд нь өөр ууттай банш өгсөн, цагаан утас гарсан банш байхгүй гэсэн тайлбар өгсөн/ Иймд хяналт шалгалт хийх боломжгүй байна.  |
| 43 | 2015.06.24 | Иргэн | Ариунаа   | Сүмтэй будаа усанд угаах юмуу дэвтээгээд тавихаар бүүр шохой шиг болоод задраад байна. Хүчит шонхор захаас авсан.  | ЧД-ийн МХХ  | 2015.06.24 | Улсын байцаагч Г.Хишигжаргал, Л.Баярмаа                            | Хэлтсийн даргын баталсан 2015.07.01-ний өдрийн 33/68 тоот удирдамжийн дагуу хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад гомдол гаргасан иргэний будаа тухайн лангуунд зарагдаж байгаагүй бөгөөд тухайн худалдагч зардаггүй гэсэн. Гомдол гаргасан иргэний цагаан будааг өөр будаагаар сольж өгч гомдлыг газар дээр нь барагдуулсан. Гомдол гаргагч иргэн тайлбар бичиж өгсөн.  |
| 44 | 2015.06.24 | Иргэн | Нарантуяа | БЗД, Газарчин дээд сургуулийн хажууд байдаг хүннү бууз баншны үйлдвэр маш бохир орчинд үйл ажиллагаа явуулж байна. Яаралтай шалгана уу   | БЗД-ийн МХХ | 2015.06.24 | Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Н.Цасчихэр   | Мэдээллийн талаар тодруулга авахаар утасдсан боловч утас нь холбогдохгүй байгаа тул өргөдлийг хаалаа.   |

|    |            |       |  |  |            |            |                               |   |
|----|------------|-------|--|--|------------|------------|-------------------------------|---|
| 45 | 2015.06.25 | Иргэн | Ангийн багш<br>Отгон                       | Говь алтай аймгийн 1 дүгээр арван жилийн 12а<br>ангийн 37 сурагч Элсэлтийн ерөнхий шалгалтыг<br>бусад ангиудаасаа ялгаатай агуулгын дагуу<br>өгсөн байна. Өмнө нь санал хүсэлт авахдаа<br>хүүхдүүдийг хүчээр гарын үсэг зуруулсан байна.<br>Эцэг эхчүүд эсэргүүцсэн боловч үл хайхарсан. | ЭМБСХГ     | 2015.06.25 | УАБ<br>Б.Эрдэнэчулуун         | Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Улсын<br>тэргүүний 1-р сургууль Лаборатори сургууль<br>бөгөөд 12А анги Туршилтын хөтөлбөрөөр<br>хичээллэдэг, багш нар нь 30% нэмэгдэл цалин<br>авдаг сургууль юм. Иймээс 2015 оны ЭЕШ-ийг<br>авахын өмнө Боловсролын үнэлгээний төвөөс<br>туршилтийн болон үндсэн хөтөлбөрөөр<br>хичээллэж байгаа эсэх талаар судлагааг<br>аймгийн Боловсрол, соёлын газраар<br>дамжуулан судалгааг гаргаж авсан бөгөөд<br>сурагчдаар гарын эсэг зурж баталгаажуулсан.<br>Туршилтын хөтөлбөр нь гүнзгий шатны<br>түвшинд хичээллэдэг. Иймээс Завхан аймгийн<br>Тосонцэнгэл, Булган аймгийн Хишиг-Өндөр<br>сумуудаас бусад туршилтын хөтөлбөрөөр<br>хичээллэдэг төгсөгчдийг үндсэн хөтөлбөрөөр<br>хичээллэдэг төгсөгчдөөс ялгаатай байдлаар<br>ЭЕШ-ийн авсан юм байна. Дээрхи 2 аймгийн<br>сургууль нь сүүлд лаборатори сургууль<br>болсон. Багш Отгонд уг асуудлын талаар<br>утсаар тайлбар хариуг өгөв. |
| 46 | 2015.06.25 | Иргэн | Цагаанхуран<br>СӨХ-ийн дарга<br>Төгссайхан | Баянзүрх дүүрэг 16-р хорооны Цагаан хуаран<br>хотхонд LCAX компани лифт суурилуулсан.<br>Лифтний паспорт өгөөгүй. Түлхүүр өгөөгүй.<br>Засвар үйлчилгээ хийхгүй гэсэн.  | НМХГ       | 2015.06.25 |                               |   |
| 47 | 2015.06.25 | Иргэн | Оюунхүү                                    | ЧД, Peace tower дэлгүүрийн баруун талд Harry<br>гоо сайхны салон нь бохир үйлчилгээтэй,<br>харилцаа муу учир эрүүл ахуй, үйл ажиллагаан<br>дээр хяналт шалгалт хийлгэх хүсэлт гаргаж<br>байна. Хөмсөг шивүүлсэн чинь идээ гарахад<br>арга хэмжээ авч өгөөгүй.                            | ЧД-ийн МХХ | 2015.06.25 | Улсын байцаагч<br>М.Мөнхгэрэл | Гомдлын дагуу хяналт хийж, 33/215 дугаар<br>бүхий албан тоотгоор хариу хүргүүлэв.   |

|    |            |       |                |  |             |            |  |  |
|----|------------|-------|----------------|--|-------------|------------|--|--|
| 48 | 2015.06.25 | Иргэн | Улдмаа         | Хэнтий аймгаас ярьж байна. Хураалгасан тамхиа буцааж авах хүсэлтэй байна. Тамхи хурааж авсан байцаагч Хэнтий аймгийн хүнс хариуцсан байцаагч Мөнхчимэг. Төвөөс шийдвэр гартал буцааж олгохгүй гэсэн хариу өгөөд байна. | ХХААХГ      | 2015.06.25 | УАБ Д.Батдулам   | Иргэн Улдмаатай 96566969 дугаарын утсаар 2015.06.29-ний 14.40 минутанд холбогдлоо. МУ-ын хууль, ЗГ-ын тогтоолын дагуу тамхийг хурааж, устгах журамтай боловч Алтангадас трейд ХХК-ны стикер нааж худалдах, дахин зөрчил гаргахгүй байх хүсэлтийг МХЕГ-ын даргад уламжилсан. Шийдвэр хараахан гараагүй байгааг тайлбарлаж, ер нь худалдаа эрхлэгчдийн хариуцлагагүй, стандарт, журам дүрмийг мэдэхгүйгээс зөрчил дутагдал гаргаж байгааг хэлж ойлгууллаа. |
| 49 | 2015.06.25 | Иргэн | Оюундэлгэр     | 13-р хорооллын Тse муудсан будаатай хоол өгсөн. Шалгуулах хүсэлтэй байна   | БЗД-ийн МХХ | 2015.06.25 | Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Ж.Дашмаа   | Тус иргэн н.Оюундэлгэрийн гомдолтой танилцаж утас руу нь холбогдож тухайн муудсан хоол буюу шалгах үндэслэлээ авчирч өгөхийг хэлэхэд тийм баримт байхгүй, хаячихаад гараад ирсэн. Өөр шошлого авсан тэр нь зүгээр байсан гэсэн хариу өгсөн тул шалгах үндэслэлгүй тул тухайн өргөдлийг хааж, иргэн Оюундэлгэрт мэдээлэв.   |
| 50 | 2015.06.25 | Иргэн | Гантуяа, Уянга | СХД, эмээлтийн төв зам дагуух "Бүрд" хүнсний дэлгүүрийн замын урд байрлах хашаанд хятадууд гэдэс юм уу түүхий эд гар аргаар боловсруулаад их муухай үнэр гарж байгаа хаягдлаа булж устгаж байна                        | СХД-ийн МХХ | 2015.06.25 | Мал амьтан хорио цээр, чанарын хяналтын улсын байцаагч С.Сэргэлэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Жавхлан | СХД дэх МХХ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу дээрх хаягаар очиж хяналт хийхэд тус газарт хариуцсан эзэн байхгүй байсан тул 2015.07.03-ны өдөр ажил дээр ирж уулзах тухай мэдэгдэх хуудас үлдээв. Шалгалтаар очиход гүзээ давсалж байсанаас гадна орчин тойронд хог хаягдал булсан хуримтлуулсан зүйл байгаагүй. Гомдол гаргасан 2 иргэний утсаар холбогдоход гомдол гаргаагүй гэсэн тул өргөдлийг хаав.   |
| 51 | 2015.06.25 | Иргэн | Уранчимэг      | Баянзүрх дүүрэг 25-р хороо Ойн 8 дугаар байшин 3 давхар байшинд байрлах Үнэ цэнэ ХХК-ны Blue Filter Ус цэвэршүүлэгчийг шалгуулмаар байна.  | БЗД-ийн МХХ | 2015.06.25 | Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч П.Нарантуяа  | Тухайн гомдол нь чиг үүрэгт хамааралгүй тул шалгах боломжгүй тул уг өргөдлийг хаав.  |

|    |            |       |              |  |            |            |   |   |
|----|------------|-------|--------------|--|------------|------------|---|---|
| 52 | 2015.06.25 | Иргэн | Энхцэцэг     | Нисэхийн хажуу талын Морингийн даваанд Цэвэрлэх байгууламж барьж байгаа байгууламж 100 гаруй ажилчинтай боловч ил гадаа хажуу орон сууцны хажууд хүүхдүүдийн дэргэд бие засах юм. Модон жорлон бариулж барьж болохгүй юм уу. | НМХГ       | 2015.06.25 | ХУД-ийн МХХ                                       | Гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд менежер Эрдэнэ-Очирыг байлцуулан хяналт шалгалт хийхэд гомдолд дурьдагдсан бие засах газар ашиглалтанд орлоо.               |
| 53 | 2015.06.25 | Иргэн | Чойбадрах    | 3-р эмнэлэгийн зүүн талд байрлах Mongol Hyundai эмнэлэгт үзүүлсэн боловч дараа нь ямар ч баримт өгөхгүй юм. Үүнийг шалгуулмаар байна. Хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа эмнэлэг бололтой.                             | МХЕГ       | 2015.06.25 | МХЕГ  | Хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож төлбөрийн баримт өгөөгүй асуудлыг МХГ шалгах боломжгүй талаар тайлбарлаж өгсөн.  |
| 54 | 2015.06.25 | Иргэн | Оюунтунгалаг | Хойд талын Бөмбөгөрийн үүдний лангуун дээрээс Фүжи Хүрээ амт будаа худалдаж авсан чинь өмхий үнэртэй, усанд хийсэн чинь үүрч унаж байна. Үүнийг шалгуулмаар байна.   | ЧД-ийн МХХ | 2015.06.25 | Улсын байцаагч<br>Г.Хишигжаргал,<br>Д.Чулуунчимэг | Хэлтсийн даргын баталсан 2015.06.29-ний өдрийн 33/65 тоот удирдамжийн дагуу хяналт шалгалт хийлээ. Гомдол гаргасан иргэн 33/211 тоот албан бичгээр хариу өгсөн. |

|    |            |       |           |   |             |            |  |  |
|----|------------|-------|-----------|---|-------------|------------|--|--|
| 55 | 2015.06.26 | Иргэн | Элбэгзаяа | Дорноговь аймгийн Даланжаргалан сум Сайн гашуут жонсны үйлдвэр байдаг ба Хятадууд ажиллуулдаг, шалгалт ирэхээр бид нарыг тараагаад, хөдөлмөрийн гэрээ, цалин нэмнэ гэдэг боловч одоог хүртэл ямар нэгэн арга хэмжээ авахгүй байна. Мөн 1 тн-ыг 4000 төгрөгөөр цэвэрлэдэг, бусад газарт дунджаар 15000 төгрөгийн үнээр цэвэрлэдэг. Иймд цалин нэмэгдүүлэх, хөдөлмөрийн гэрээг байгуулах асуудлыг, мөн гэнэтийн шалгалт хийж өгнө үү. | ХНХХГ       | 2015.06.26 | Дорноговь аймгийн МХГ  | тус уурхайд 2015.06.08-нд Уурхай ашиглалтанд хүлээн авах улсын комисс ажиллаж уурхайн бичиг баримтууд бүрдүүлэх хүртэл хугацаагаар үйл ажиллагааг түр зогсоосон, 2015.06.10-нд МХГ-ыг төлөвлөгөөт шалгалтын хэсэг ажиллахад монгол ажилчдаа амраасан, хятал ажилчид 8 хүн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй ажлын байрны төлбөрөө төлсөн визийн хугацаа сард дуусах тул хугацаа сунгуулахаар бичиг баримтаа төв компани руугаа явуулсан байсан. Хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хүссэн ажилчин хүн ажил олгогчоо урьдчилан судалж, тэдний хөдөлмөрийн дотоод журам, үндсэн үйл ажиллагааны чиглэл бусад мэдээлэлтэй танилцаж, ажлын хөлс, гүйцэтгэх ажлын хэмжээ, чиг үүргээ тодорхой болгосны дараа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилаа эхэлж байх талаар зөвлөгөө өгч, хяналтын байгууллагад мэдээлэл өгөхдөө асуудлыг баримтжуулж байх хэрэгтэй, таны өгсөн мэдээллийн дагуу шалгалт хийх боломжгүй байна гэж мэдэгдлээ. |
| 56 | 2015.06.26 | Иргэн | Ганбат    | Жуковын Everyday –гийн хойд талын солонгос дэлгүүрээс Sakura будааг худалдаж аваад угаасан чинь бутраад унасан. Тухайн үед зургийг нь аваад Facebook –д тавьсан чинь тухайн компаниас залгаад шүүхдэнэ гэж хэлсэн. Энэ будааг шалгуулмаар байна.  | БЗД-ийн МХХ | 2015.06.26 | Ургамал хорио цээр ч анарын хяналтын улсын байцаагч Д.Цэгмэд           | Иргэн Ганбатаас мэдээлэл авах гэж утсаар нь холбогдоход 1 кг будаа авсан боловч дэлгүүрийн талон байхгүй, будаа нь байхгүй тул нотлох баримтгүй тул шалгах боломжгүй байна гэж өөрт нь хариу мэдээлэв.   |
| 57 | 2015.06.26 | Иргэн | Ариунзаяа | Шөнийн захад 500 гаруй түрээслэгчтэй боловч ариун цэврийн өрөө ажлуулахгүй 1 ариун цэврийн өрөө ажлуулахаар ачаалалаа даахгүй байна. Мөн агааржуулалт байхгүй. Үүнийг тус компанид хэлэхээр ямар ч арга хэмжээ авч өгөхгүй байна. Үүнийг шалгуулмаар байна.   | БЗД-ийн МХХ | 2015.06.26 | Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч Н.Амарзаяа | Тус гомдлыг шалгах боломжгүй хяналтын чиг үүрэгт хамааралгүй тул тухайн иргэнд хариу мэдээлэв.   |

|    |            |       |                |  |             |            |                        |   |
|----|------------|-------|----------------|--|-------------|------------|------------------------|---|
| 58 | 2015.06.29 | Иргэн | Ж.Ганцэцэг     | Дорноговь аймгийн Замын үүдэд 65 айлын орон сууцад заслын ажил хийсэн "Голдэн ситик" ХХК" цалин өгөхгүй байна, хянаж шалгаж өгөөч.   | ХНХХГ       | 2015.06.29 | Дорноговь аймгийн МХГ  | Гомдол гаргасан иргэнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулахыг хүссэн тал нь харилцагчаа урьдчилан судлаж, тэдний хөдөлмөрийн дотоод журам, үндсэн үйл ажиллагааны чиглэл бусад мэдээлэлтэй танилцаж ажлын хөлс, гүйцэтгэх ажлын хэмжээ, чиг үүргээ тодорхой болгосны дараа гэрээ байгуулж ажлаа эхэлж байх талаар зөвлөгөө өгч, хяналтын байгууллагад мэдээлэл өгөхдөө асуудлыг баримтжуулж байх хэрэгтэй, таны өгсөн мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх боломжгүй байгааг мэдэгдлээ. |
| 59 | 2015.06.29 | Иргэн | Р.Мөнгөнчулуун | Барс захын гадаад контейнер сүмтэй цагаан будаа 25 кг усанд ороод шохой болж байна. Шалгаж өгнө үү.  | БГД-ийн МХХ | 2015.06.29 | УХЦЧХУБ<br>М.Сэрсэнжав | БГД-ийн иргэн Р.Мөнгөнчулууны ирүүлсэн гомдлын дагуу 2015 оны 07-р сарын 05-ны өдөр Барс худалдааны төвийн 9-р континейрт цагаан будаа худалдаалж байгаа иргэн Ч.Оюунчимэгийн цагаан будаанаас дээж авч МХЕГ-ын төв лабораторт шинжилгээнд хамруулахад уг цагаан будаа шаардлага хангаж байсан тул улсын байцаагчийн дүгнэлт гаргаж ажилласан. Иргэнд утсаар хариу мэдэгдсэн.   |
| 60 | 2015.06.29 | Иргэн | Ганцэцэг       | Орон сууцны давхар нэмж буй асуудал БГД 12-р хороо,6-р бичил хороолол, 7а, б, в байр хянаж шалгаж өгөөч, 3 долоо хоногийн өмнө МХГ болиулсан, Шуурхай албаны хүн ирээд явсан, одоо ажиллаад байна. | НМХГ        | 2015.06.29 | Дорноговь аймгийн МХГ  | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулахыг хүссэн тал нь харилцагчаа урьдчилан судлаж, хөдөлмөрийн дотоод журам, үндсэн үйл ажиллагааны чиглэл бусад мэдээлэлтэй танилцаж ажлын хөлс, гүйцэтгэх ажлын хэмжээ, чиг үүргээ тодорхой болгосны дараа гэрээ байгуулж ажилаа эхэлж байх талаар зөвлөгөө өгч, хяналтын байгууллагад мэдээлэл өгөхдөө асуудлыг баримтжуулж байх хэрэгтэй, таны өгсөн мэдээллийн дагуу шалгалт хийх боломжгүй байна гэж мэдэгдлээ.                                   |
| 61 | 2015.06.30 | Иргэн | Сайханзаяа     | Хүнсний 1 дэлгүүрийн замын зүүн талд байдаг ХХБ-ны хойд талын хүнсний дэлгүүрээс сүү авсан чинь эздээд тараг болсон байна. Энэ асуудлыг шийдэж өгнө үү.  | МХЕГ        | 2015.07.01 | МХЕГ                   | Хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож асуудлыг тодруулахад сүүгээ буцааж өгөөд мөнгөө авсан тул гомдолгүй гэсэн хариу өгсөн. Иийд гомдлыг хаав.  |

|    |            |       |             |   |             |            |  |   |
|----|------------|-------|-------------|---|-------------|------------|--|---|
| 62 | 2015.06.30 | Иргэн | Туяацэцэг   | 13 дугаар хороолол явдаг гүүрэн дээр байрлалтай "Далай таурын" 2 давхарт "Элэг" төв гэж байгаа тусгай зөвшөөрөл байхгүй хэрнээ үзлэг хийгээд сорьц аваад байна. Эмнэлгийн шаардлага стандарт хангаагүй орчин нөхцөл нь бохир байна. Тусгай зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж өгнө үү. | БЗД-ийн МХХ | 2015.06.30 | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч П.Төгсмаа | Тус иргэний гаргасан өргөдлийн дагуу иргэн н.Туяацэцэг рүү утасдаж асуухад би мэдээлэл өгөөгүй гэсэн хариу өгсөн. Тус эмнэлгийн байдалтай танилцахаар судлахад СБД-ийн 1-р хорооны харъяа тул тус хэлтэс шалгах үндэслэлгүй болно.  |
| 63 | 2015.06.30 | Иргэн | Мягмарсүрэн | Саппорогын "Миний дэлгүүр"-ээс бөмбөөлэй гэж савласан будаа авсан чинь резин үнэртээд байна. Мөн идэж болохгүй байна. Савласан компани нэр нь: "Ти Эм Ти" ХХК гэсэн байна. Утас: 70177077   | СХД-ийн МХХ | 2015.06.30 | улсын байцаагч Л.Долгормаа, Ба.Энхцэцэг                          | Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж тус дэлгүүрт худалдаалагдаж буй задгай будаанаас дээж авч НМХГ-ын төв лаборатори, МХЕГ-ын Үндэсний лавлагаа лабораторид шинжилгээнд тус тус хамруулахад шаардлага хангасан үзүүлэлттэй байна. Шинжилгээний хариуг 88199977 утсаар холбогдож хариу өгч ажиллалаа                                  |
| 64 | 2015.06.30 | Иргэн | Болормаа    | Сэрүүлэг дээд сургууль урд талд баригдаж байгаа барилгаас мод, чулуу, төмрийг доош нь шууд шидээд байна. Миний машины хамран дээр төмөр унасан. Энд явган хүн явах боломж алга хүний амь нас эрсдэхэд бэлэн байна. Шалгаж өгнө үү.  | НМХГ        | 2015.06.30 | ХНХХХ  | Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд тухайн барилга нь НМХГ-ын улсын ахлах байцаагчийн акттай боловч барилга угсралтын ажил явагдаж байсан тул ажилчдыг барилгын талбайгаас гаргаж, удирдах тушаалтнуудад актын биелэлтийг ханган ажиллахыг үүрэг болгов. БГД-ийн цагдаагийн 1-р хэлтэсийн 11 хорооны хэсгийн цагдаа нартай хамтран ажилласан. |





